

ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ ТЭГЛЭХ ЗОРИЛТЫГ ҮНДЭСНИЙ ТҮВШИНД ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

ГДТ зорилтыг тодорхойлох суурь нөхцөл



THE GLOBAL
MECHANISM

2015 оноос газрын доройтлыг тэглэх (ГДТ) зорилтыг улс орон бүрт хангах зорилгоор үндэсний ГДТ зорилтуудыг тодорхойлох үйл явц дэлхий нийтээр хэрэгжиж байгаа бөгөөд одоогийн байдлаар нийт 108 улс энэ үйл явцад хамрагдаад байна. НҮБ-ын ЦТК-ийн Даян Дэлхийн Механизмаас боловсруулсан энэхүү мэдээллийн товхимолын хураангуйг ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн Хүрээлэнгийн Цөлжилтийн Судалгааны Төвөөс та бүхэнд танилцуулж байна.

ГДТ үндэсний зорилтын тодорхойлоход анхаарах асуудал болон хэрхэн яаж энэ үйл явцыг эхлүүлэх талаархи зөвлөмжийг загвар төслүүдээс гарсан голлох сургамжуудын хамтаар энд хураангуйлан оруулж таниулахыг зорилоо.



**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**



GLOBAL ENVIRONMENT FACILITY
INVESTING IN OUR PLANET



*Empowered lives.
Resilient nations.*

Энэхүү товхимолыг БОАЖЯам ба НҮБХХ-ийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” МОН/16/301 төслийн дэмжлэгээр хэвлэв.

Даян дэлхийн санаачлагыг үндэсний түвшинд хэрэгжүүлэх нь

2030 он хүртэлхи тогтвортой хөгжлийн хэлэлцэх асуудлууд нь дэлхий нийтийг тогтвортой замд хөтлөх хамгийн зоригтой, том хэмжээний хүсэл эрмэлзлийг тодорхойлж буй билээ. Газрын доройтолгүй дэлхий болох зорилт нь энэхүү хэлэлцэх асуудлын гол тулгуур зорилт болж байгаа юм.

Өнөөдөр дэлхийн 100 гаруй орон Газрын Доройтлыг Тэглэх даян дэлхийн зорилтыг өөрийн орны нөхцөл байдалд тохируулан үйл ажиллагаа, хөгжлийн хөтөлбөрийн зорилго болгох амлалтыг аван ажиллаж байна. Эдгээр үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, өлсгөлөнг зогсоох, цэнгэг усны хүртээмж, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг олон талын эерэг үр нөлөөг авчирна.

НҮБ-ын ЦТК, Даян Дэлхийн Механизм олон арван хоёр талт болон олон талт гэрээ хэлэлцээрийн хүрээнд улс орнуудад ГДТ өөрийн зорилтыг тодорхойлох үйл явцад нь дэмжлэг үзүүлж байна. Энэхүү товхимолд танилцуулж буй суурь нөхцлүүд нь гишүүн орнууд болон бусад оролцогч талуудын хүрээнд хийсэн олон түвшний уулзалт зөвлөгөөний үр дүн юм. Түүнчлэн эдгээрт ГДТ загвар төсөл хэрэгжсэн 14 улс орны энэхүү үзэл баримтлалыг амьдралд нэвтрүүлэхэд хуримтлуулсан туршлага, сургамжийн үр дүн билээ.

ГДТ зорилтыг тодорхойлох үйл явц нь улс орнуудад уялдаа холбоог дээшлүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх, бүх талын нөөцийг татан оролцуулах боломжийг давхар олгож байна. Нэгдүгээрт, ГДТ зорилтыг үндэсний бодлого, арга хэмжээ, амлалт, шийдвэрийн (уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, ХАА-н бодлого, нөхөн сэргээх амлалт) уялдаа холбоог тодорхойлох гол хөшүүрэг болгон ашиглаж болно. Хоёрдугаарт, олон жижиг, энд тэнд туршсан туршилт судалгаанаас том талбайг хамарсан, шинэчлэлийг авчрах, зоригтой шийдэл бүхий ГДТ хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлд шилжих. Гуравдугаарт, газрын доройтлыг тэглэх бодлогыг хэрэгжүүлэхэд санхүүгийн холимог багцыг бий болгох, ингэхдээ төсвийн, хувийн, үндэсний, олон улсын уур амьсгалын болон хөгжлийн санхүүгийн эх үүсвэрүүдийг зохистой хослуулах.

Бид өөрийн хамтрагч талуудын оролцоотойгоор гишүүн орнуудадаа эдгээр боломжийг нээн илрүүлэх, ашиглахад нь дэмжлэг үзүүлэх үүргийг хүлээж байна. Газрын Доройтлыг Тэглэх зорилтыг гүйцэлдүүлэхэд бүгдээрээ хамтаар зоригтой алхам хийж нэг улсаас нөгөө улсад энэ зорилтыг биелүүлцгээе.

Маркус Репник

НҮБ-ын Даян Дэлхийн Механизмын
Зохицуулах Захирал



ОРШИЛ

Цөлжилт, газрын доройтол нийт 100 гаруй улс орны нутаг дэвсгэрт илрэлээ олж 1 тэрбум хүний амьдрал ахуйд нөлөөлж байна¹. Жил бүр 12 сая га хөдөө аж ахуйн газар ганд нэрвэгдэн доройтож байна². Дэлхийн хэмжээнд ажиглагдаж буй газрын доройтол, цөлжилтийн үйл явц нь уур амьсгалын өөрчлөлт, хүн амын өсөлт, байгалийн нөөцийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ зэрэгтэй уялдан улам бүр нэмэгдэх хандлагатай байгаа тул нэн даруй, ихээхэн хүчин чармайлтаар түүнийг зогсоох шаардлага урган гарч байна. Цөлжилт, газрын доройтол дэлхийн эдийн засагт жилд 490 тэрбум долларын хохирол учруулж байна. Харин газрын тогтвортой менежментийг нэвтрүүлэх замаар газрын доройтлыг бууруулснаар 1.4 их наяд доллартай тэнцэхүйц ашгийг бий болгож болно³.

Газрын доройтлыг бууруулах бодлого, хөтөлбөрүүд нийтлэг том зорилго, тоон шалгуур, үйл ажиллагааг хөтлөн явуулах тодорхой хугацаа заасан зорилт, ахиц дэвшлийг тодорхойлох шалгуургүй явц ирсэн нь тэдгээрийн хэрэгжилт сул байсныг илтгэнэ. 2015 оны 10-р сард НҮБ-ын ЦТК-ийн бүхий л Талууд өмнө байгаагүй том зөвшилцөлд хүрч Газрын Доройтлыг Тэглэх (ГДТ) зарчмыг буй болгосон.

ГДТ зорилтыг тодорхойлох хөтөлбөрийн үйл явц

НҮБ-ын ЦТК-ийн Талуудын 12-р бага хурлаар (COP 12) талууд тогтвортой хөгжлийн зорилтууд (SDGs) ялангуяа Газрын Доройтлыг Тэглэх 15.3 зорилтыг Конвенцийн хэрэгжилтэнд уялдуулах шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрч “Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ын зорилго 15.3-ыг гүйцэлдүүлэх нь НҮБ-ын ЦТК-ийн хэрэгжилтийг хангах гол хөдөлгөгч хүч юм” гэж томъёолжээ (COP 12/шийдвэр 3). Үүнээс гадна, COP 12-оос “газрын доройтол өнөөдөр хуурай, гандуу, чийг дутмаг бүс нутгаас гадна бусад бүсүүдэд их хэмжээгээр илэрч байна” гэж онцлон “цөлжилт, газрын доройтол, гангийн нөлөөг бууруулах өөрийн үндэсний болон бүс нутгийн хэмжээний бодлогодоо талууд НҮБ-ын ЦТК-ийг түшиглэж, сайн дураараа зорилтуудаа тодорхойлж газрын доройтлыг тэглэх зорилтод тэмүүлэх хэрэгтэй” гэж үзжээ. Эдгээр шийдвэр нь ТХЗ-ууд болон 15.3 зорилтыг НҮБ-ын ЦТК-ийн хэрэгжилтэнд уялдуулж улс орнуудыг 2030 он гэхэд газрын доройтлыг тэглэх өөрийн зорилтуудыг сайн дурын үндсэн дээр тодорхойлохыг уриалсан юм.

Эдгээр шийдвэрийг улс орнууд өөрийн хэмжээнд

хэрэгжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх зорилгоор НҮБ-ын ЦТК-ийн Шинжлэх Ухаан ба Бодлогын Зөвлөлөөс (SPI) (4) газрын доройтлыг тэглэх шинжлэх ухаанд суурилсан үзэл баримтлалыг боловсруулсан бөгөөд энэ нь ГДТ үзэл санаа, ГДТ үйл ажиллагааг зөв төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд мониторинг хийх олон талт мэдээллийг агуулсан байна.

COP 12-оос улс орнуудад ирэх 15 жилийн замын зургийг тодорхойлж өгсөн. Өнөөдрийн гол зорилго нь энэ санаачлагыг ашиглаж урагш хөдлөх явдал юм. НҮБ-ын ЦТК-ийн Даян Дэлхийн Механизмаас санаачлан хэрэгжүүлж буй ГДТ зорилтыг тодорхойлох хөтөлбөр нь одоогийн байдлаар 10 гаруй хоёр талт болон олон талт түншүүдийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байна. Энэ хөтөлбөр нь улс орнуудад 2030 он гэхэд ГДТ үзэл баримтлалыг бодит хөрсөнд буулгахад нь дэмжлэг үзүүлэхэд орших бөгөөд юуны түрүүнд ГДТ зорилтуудыг өөрийн улс орондоо тодорхойлох, эерэг өөрчлөлт үзүүлж болох томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хурдасгахад практик арга хэрэгсэл, зөвлөмж өгөх хэлбэрээр хэрэгжиж байна.

ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ ТЭГЛЭХ ГЭЖ ЮУ ВЭ?

НҮБ-ын ЦТК-ийн Талуудын 12-р бага хурлаас ГДТ гэдгийг “цаг хугацаа, орон зайн экосистемийн хэмжээнд экосистемийн үүрэг, үйлчилгээг дэмжих, хүнс тэжээлийн аюулгүй байдлыг тогтвортой байлгах, улам сайжруулахад шаардлагатай газрын хэмжээ, чанар тогтмол байх төлөвийг ойлгоно” гэжээ.

ГДТ үзэл баримтлал нь эрүүл, бүтээмжит газрыг алдахгүй байх нөхцлийг бүрдүүлэхийн тулд газрын доройтлоос зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохистой хослуулан хэрэгжүүлэхийг хөхүүлэн дэмжихэд чиглэсэн. ГДТ зорилго нь газрыг нөхөн сэргээх, газрын тогтвортой менежментийг нэвтрүүлэх замаар нэмэлт ашиг орлогыг бий болгох арга хэмжээг газрын баялгийн хомсдолыг зогсоох, улмаар экосистемийн үүрэг, үйлчилгээг сайжруулах үйл ажиллагаа хоорондын тэнцвэрийг бий болгоход оршино.

ГДТ нь энгийн сэдэл мэт боловч хэрэгжсэнээр маш хүчирхэг хэрэгсэл болж чадна. Өөрөөр хэлбэл, газрын доройтлоос зайлсхийх замаар эрүүл, бүтээмжит газрын нөөц баялгийг хамгаалж, хаана боломжтой байна, тэнд доройтсон газрыг нөхөн сэргээх явдал юм. Энэ үзэл баримтлалын тулгуур хүчин зүйл нь өнөө болон ирээдүй хойч үеийнхэнд эдийн засгийн, нийгмийн, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан өгөхөд газрын менежментийн зөв арга барилыг хэвшүүлэх, газар ашиглалтын төлөвлөгөөг зөв боловсруулах явдал юм. ГДТ болон тогтвортой хөгжлийн бусад зорилтууд хооронд хэд хэдэн нийтлэг холбоос бий. Тухайлбал, ядуурлыг бууруулах, хүнс тэжээлийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах чиглэлд ГДТ бодлогын үр нөлөө асар их юм. ГДТ зорилт нь эдгээр зорилтод хүрэх замыг дөтөлж өгнө.

ГДТ ба уур амьсгалын өөрчлөлт

ГДТ зорилт нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах болон түүнд дасан зохицох асуудалд чухал үр нөлөөтэй. Газрын доройтлоос урьдчилан сэргийлж, түүнийг нөхөн сэргээснээр хүлэмжийн хийг ялгаруулж буй доройтсон газруудыг шингээгч болгон хөрс, ургамал дахь нүүрстөрөгчийг нэмэгдүүлэх юм. Үүнээс гадна, ГДТ нь хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөнд эмзэг байдлыг бууруулах, тэдгээрт нэн хэрэгцээтэй экосистемийн үйлчилгээний хангамжийн эрсдэлийг бууруулж, сайжруулах явдал юм.

Газар болон уур амьсгал хоорондын эдгээр холбоо нь 2015 онд Парис хотноо болсон НҮБ-ын УАӨСК-ийн талуудын 21-р бага хуралд улс орнуудын хүргүүлсэн Үндэсний Оруулах Хувь

Нэмэрт тусгалаа олсон байдаг. Үндэсний Оруулах Хувь Нэмэрт 100 гаруй зөвхөн газар, түүний нөөц баялагтай холбоотой бууруулах, дасан зохицох үйл ажиллагаа бий. ГДТ зорилтын хэрэгжилт нь үндэсний уур амьсгалын хөтөлбөрүүдийн хэрэгжилтээс хамааралтай байхаас гадна тэдгээрт мөн нөлөө үзүүлнэ. Ийм уялдаа холбоог ГДТ зорилтын хүрээнд улс орны зорилтыг тодорхойлоход мөн тооцох шаардлагатай бөгөөд Парисын Хэлэлцээрийн хүрээнд батлагдсан Үндэсний Оруулах Хувь Нэмрийг мөн шинэчлэх хэрэгцээ бий болно.

6.1 нийт хүн амыг аюулгүй, хямд ундны усаар тэгш хангах
6.4 ус ашиглалтын үр ашгийг үлэмж дээшлүүлэх
6.5 усны нөөцийн нэгдсэн менежментийг бүх түвшинд хэрэгжүүлэх
6.6 усан орчны экосистемүүдийг хамгаалах, нөхөн сэргээх



15.1 Экосистем, түүний үйлчилгээг хамгаалах, нөхөн сэргээх
15.2 Ойн тогтвортой менежментийг дэмжих
15.4 уулын экосистемийг хадгалах
15.5 байгалийн амьдрах орчны доройтлыг бууруулах
15.8 Харийн, харш төрөл зүйлийн нөлөөг бууруулах
15.9 Бодлого төлөвлөлтөд экосистем болон биологийн төрөл зүйлийн үнэлгээг тусгах



13.1 уур амьсгалтай холбоотой гамшигтай тэмцэх, дасан зохицох чадавхийг бэхжүүлэх
13.2 Үндэсний бодлого, стратеги, төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг тусгах



1.1 Нэн ядуурлыг бүрэн устгах
1.2 Ядуу хүн амын хувь хэмжээг бууруулах
1.4 Газар эзэмшил, газрын нөөцийг ашиглах тэгш эрхийг хангах
1.5 Уян хатан байдлыг бэхжүүлэх, эмзэг байдлыг бууруулах



1.1 Нэн ядуурлыг бүрэн устгах
1.2 Ядуу хүн амын хувь хэмжээг бууруулах
1.4 Газар эзэмшил, газрын нөөцийг ашиглах тэгш эрхийг хангах
1.5 Уян хатан байдлыг бэхжүүлэх, эмзэг байдлыг бууруулах

12.3 дэлхийн хүнсний хаягдлыг бууруулах



7.2 Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг үлэмж нэмэгдүүлэх

15.3

2030 он газрын доройтолгүй дэлхий зорилтод хүрэх

Газрын доройтлыг тэглэх нь Тогтвортой хөгжлийн зорилтуудын хурдасгуур юм

ГДТ зорилтыг тодорхойлох суурь нөхцөл

ГДТ үндэсний зорилтыг тодорхойлох үйл явц нь НҮБ-ын ЦТК-ийн Шинжлэх ухаан ба Бодлогын зөвлөл болон гишүүн орон, бусад талуудын ирүүлсэн саналд үндэслэн үндсэн 4 суурь нөхцлөөс бүрдэнэ. Эдгээр нь бүх бүс нутгийг төлөөлүүлэн нийт 14 улсад хэрэгжсэн Үндэсний Зорилт Тодорхойлох Хөтөлбөрийн загвар төслүүдийн анхан шатны сургамжуудаас олсон мэдлэгт суурилсан болно. Эдгээр суурь нөхцлүүд нь:

3. ГДТ зорилтууд ба холбогдох арга хэмжээг тодорхойлох.

ГДТ зорилтууд нь тухайн улс орны газрын доройтлыг бууруулах чиглэлд баримталж буй чин хүслийг тодорхойлно. ГДТ арга хэмжээ нь доройтлоос зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх хэд хэдэн үйл ажиллагааг өөртөө багтаана.

1. ГДТ зорилтыг хөшүүрэгдэх

ГДТ нь тусгаар зорилт биш боловч газрын нөөцийн менежменттэй уялдаатай яам, салбаруудыг зохицуулах боломжийг бий болгоно. Яагаад ГДТ хэрэгтэй гэж? Бид юу ашиглах хэрэгтэй вэ? Хэн энэ асуудлыг эрхлэх вэ? Хэн энд оролцох шаардлагатай вэ? Гэсэн асуултанд нийтлэг хариулт олох нь чухал.

2. ГДТ зорилтын хэрэгжилтийг үнэлэх.

Газрын доройтол ба түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг үнэлэх нь ГДТ-г тодорхойлох суурь нөхцөл бөгөөд ямар арга хэмжээ авах, арга хэмжээний ахиц дэвшлийг дүгнэхэд мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргах нь чухал.

4. ГДТ зорилтыг хангах.

Нээлттэй орчин бүрдүүлэх нь ГДТ зорилтыг гүйцэлдүүлэхэд чухал үүрэгтэй. Ингэснээр ГДТ үзэл баримтлалыг үндэсний бодлогод тусгах, өөрчлөлт шинэчлэл авчрах төсөл, хөтөлбөрийг тодорхойлох үйл явцыг хялбаршуулж өгнө.

1.

ГДТ зорилтыг хөшүүрэгдэх

Гол үр дүн ба үр нөлөө:

- “Үндэсний ГДТ зорилт тодорхойлох хөшүүрэг төлөвлөгөө”-г боловсруулснаар үндэсний онцлогт тохирсон боломжуудыг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлнэ.
- Төрийн захиргааны төв байгууллага болон олон улсын хамтрагч талуудыг таган оролцуулснаар ГДТ зорилтыг тодорхойлох үйл явцад дэмжлэг үзүүлнэ.
- ГДТ зорилт тодорхойлох үйл явцад гол сонирхогч талуудын оролцоог бүрэн хангахуйц олон талт оролцоог бүрдүүлнэ.

3.

ГДТ арга хэмжээг тодорхойлох

Гол үр дүн ба үр нөлөө:

- ГДТ улс орны чин хүслийг тодорхойлох ГДТ зорилтуудыг тогтооно.
- ГДТ зорилтод хүрэхэд нөлөөлөх бодлогын болон техник арга хэмжээнүүдийг тодорхойлно.
- Газрын доройтлоос зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх Засгийн газрын дээд түвшний нот бичиг боловсруулна.

2.

ГДТ зорилтыг үнэлэх

Гол үр дүн ба үр нөлөө:

- ГДТ суурь мэдээллийг цуглуулж зурагласнаар ГДТ суурь мэдээллийн хүрээг үүсгэнэ.
- ГДТ зорилтын хүрээнд хууль эрхзүйн болон институцийн орчинд дүн шинжилгээ хийж ГДТ зорилтын хэрэгжилтийг хангахад нөлөө үзүүлэх боломжууд болон эрсдлүүдийг тодорхойлно.
- ГДТ үйл ажиллагааны хандлага ба хүчин зүйлсийг зураглах замаар ГДТ зорилтод хүрэх тэргүүлэх ач холбогдолтой газар нутгийг сонгоно.

4.

ГДТ зорилтыг хангах

Гол үр дүн ба үр нөлөө:

- Үндэсний голлох бодлого, амлалт, баримт бичгүүдэд ГДТ зорилтыг тусгана.
- Өөрчлөлт шинэчлэл авчрах томоохон төсөл, хөтөлбөр болон санхүүжилтийн шинэлэг загварын жишиг баримт бичиг бүрдэнэ.

Суурь Нөхцөл 1: ГДТ Зорилтыг Хөшүүрэгдэх

Үндэсний ГДТ зорилт тодорхойлох хөшүүрэг төлөвлөгөө боловсруулах

ЯАЖ?

ГДТ хөшүүрэг
төлөвлөгөө

Яагаад ГДТ чухал вэ?

- Олон талын ашигтай
- Бодлого уялдана
- УАӨ үйл ажиллагаа
- Санхүүгийн боломж нэмэгдэнэ

Хэн оролцох вэ?

- ЗГ-ын чиг үүргийн яамд
- Үндэсний механизмууд
- Олон улсын хөгжлийг дэмжих хамтрагч нар
- Үндэсний оролцогч талууд

Юуг хөшүүрэгдэх вэ?

- Үндэсний хөгжлийн зорилт
- Улсын амлалт ба үүрэг

Суурь Нөхцөл 1: ГДТ Зорилтыг Хөшүүрэгдэх

Сонирхогч талуудыг оролцуулах:
ГДТ ажлын бүлэг



Ямар үр дүн хүлээж байна вэ?

- “Үндэсний ГДТ зорилт тодорхойлох хөшүүрэг төлөвлөгөө”-г боловсруулснаар үндэсний онцлогт тохирсон боломжуудыг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлнэ.
- Төрийн захиргааны төв байгууллага болон олон улсын хамтрагч талуудыг татан оролцуулснаар ГДТ зорилтыг тодорхойлох үйл явцад дэмжлэг үзүүлнэ.
- ГДТ зорилт тодорхойлох үйл явцад гол оролцогч талуудын оролцоог бүрэн хангахуйц олон талт оролцоог бүрдүүлнэ.

ГДТ Зорилт тодорхойлох хөтөлбөрөөс оролцогч орнуудад ямар дэмжлэг үзүүлэх вэ?

- ГДТ хөшүүргийг бий болгох үндэсний онцлогт тохирсон боломжуудыг илрүүлэх, “Үндэсний ГДТ зорилт тодорхойлох хөшүүрэг төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;
- Засгийн газрын гол бүтэц болон олон улсын хамтрагч байгууллагуудыг ГДТ зорилт тодорхойлох үйл явцад оролцуулах нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;
- Үндэсний ГДТ ажлын бүлэг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар бүхий л сонирхогч талуудын оролцоог хангах, үндэсний зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Суурь нөхцөл 2. ГДТ зорилтын хэрэгжилтийг үнэлэх

ТХЗ 15.3-ын хэрэгжилтэнд мониторинг хийх, тайлагнах ажлын хүрээ

ТХЗ-ын шалгуур үзүүлэлт 15.3.1


Доройтсон газрын
нийт талбайд эзлэх
хувь




Дэд шалгуур
үзүүлэлт:
НҮБ-ын
ЦТК (БТЗК,
УАӨСК)-ийн
тайлагнах
механизм



Олон эх
үүсвэрээс
мэдээлэл
бүрдүүлэх





ГДТ Зорилт тодорхойлох хөтөлбөрөөс оролцогч орнуудад ямар дэмжлэг үзүүлэх вэ?

- Даян дэлхийн мэдээллийн эх үүсвэр ашиглан ГДТ суурь мэдээ болон хандлагыг үнэлнэ
- Үндэсний хэмжээнд ГДТ суурь мэдээлэл болон хандлагыг тодорхойлох аргазүйн зөвлөмж өгнө.
- ГДТ хууль эхзүй болон институцийн зорилтод дүн шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлнэ.



Ямар үр дүн хүлээж байна вэ?

- ГДТ суурь мэдээллийг цуглуулж зурагласнаар ГДТ суурь мэдээллийн хүрээг үүсгэнэ.
- ГДТ зорилтын хүрээнд хууль эрхзүйн болон институцийн орчинд дүн шинжилгээ хийж ГДТ зорилтын хэрэгжилтийг хангахад нөлөө үзүүлэх боломжууд болон эрсдлүүдийг тодорхойлно.
- ГДТ үйл ажиллагааны хандлага ба хүчин зүйлсийг зураглах замаар ГДТ зорилтод хүрэх тэргүүлэх ач холбогдолтой газар нутгийг сонгоно.

Суурь нөхцөл 3: ГДТ зорилтууд ба холбогдох арга хэмжээг тодорхойлох

ГДТ хариу үйлдлийн шатлал

2. Бууруулах

Газрын доройтолд бодит заналхийлэл учруулж болох үйл ажиллагааны хэлбэрийг илүү тогтвортой, зохистой хэлбэрт шилжүүлэх замаар доройтлын үйл явцыг сааруулах боломжтой. Энд газрын тогтвортой менежментийн арга хэлбэрүүд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Төлөвлөлтийн нэг зарчмын хувьд ГДТ үйл явц нь доройтолд үзүүлэх хариу үйлдлийг шаталсан тогтолцоогоор шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд зайлсхийх стратегийг илүү чухалчилна. “Урьдчилан сэргийлэх нь сэргээн босгохоос илүү үр дүнтэй юм”.

1.Зайлсхийх

Газрын доройтлын олон хэлбэрээс зөв арга хэмжээг авч хэрэгжүүлснээр зайлсхийж болох бөгөөд ингэснээр доройтолд өртөх талбайг дорвитой бууруулж болох юм. Энд газрын нөөцийг зөв зохицуулах, газар ашиглалтыг зохистой төлөвлөх, үйл ажиллагааны боломжит загваруудыг бий болгох зэрэг хамаарна.

3. Нөхөн сэргээх

Газрын үржил шим, бүтээмжит чанар болон газраас үзүүлэх экосистем эргэн сэргэх боломжтой газарт нөхөн сэргээх үйл ажиллагаагаар дамжуулан байгалийн сэргэн ургах чадавхийг дээшлүүлэх боломжтой.

Суурь нөхцөл 3: ГДТ зорилтууд ба холбогдох арга хэмжээг тодорхойлох

Газрын доройтлоос зайлсхийж болохгүй буюу алдагдлыг өөр газарт нөхөн сэргээх замаар тэнцвэржүүлэх

Доройтлоос зайлсхийж болохгүй нөхцөлд төлөвлөлтийн түвшинд нөхөн сэргээгдэх боломжит газруудад нөхөн сэргээлтийг хийх замаар алдагдлыг шийдэж болно. Энэ нь ГДТ үзэл баримтлалын бусад ижил төсөөтэй зорилт, санаачлагаас ялгарах бас нэг онцлог нь юм.



Доройтож болзошгүй газар

Сайжруулах шаардлагатай газар



Ирээдүйд доройтол илрэх

Ирээдүйд ашиг бүрдэх



Газрын доройтол шинээр явагдаж болзошгүй газар нутаг

Зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх үйл ажиллагаа хэрэгжүүлснээр ирээдүйд эерэг нөлөө бий болж болох газар

Суурь нөхцөл 3: ГДТ зорилтууд ба холбогдох арга хэмжээг тодорхойлох

Газрын тогтвортой менежментийн дөрвөн төрөл

Хөдөө аж ахуйн арга хэмжээ:

Хөрсний гадарга, бүтэц, үржил шимийг дээшлүүлэх аливаа үйл ажиллагааг энд хамруулна. Тухайлбал, тэг боловсруулалт, компостлох, бордох, давсжилтыг бууруулах г.м.

Ургамлын арга хэмжээ:

Мод, бут суулгах, олон наст тариалах зэрэг замаар доройтсон гадргагы ногооруулах бүхий л үйл ажиллагаа.

Инженерийн арга хэмжээ:

дэвсэг байгуулах, налууг шатлах, хаалт, хамгаалалт барих зэрэг замаар хөрсний элэгдэл эвдрэлийг бууруулах ажлууд.

Менежментийн арга хэмжээ:

газар ашиглалтын арга хэлбэрийг өөрчлөх, ашиглалтын эрчимийг зохицуулах, хяналт, судалгаа, үнэлгээ явуулах замаар хугацаа, хамрах хүрээг тэлэх эсвэл хумих бодлогыг авах.

Ямар үр дүн хүлээж байна вэ?

- ГДТ зорилтууд тодорхой болно.
- ГДТ зорилтод хүрэхэд нөлөөлөх бодлогын болон техник арга хэмжээнүүдийг тодорхойлно.
- Газрын доройтлоос зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх Засгийн газрын дээд түвшний нот бичиг боловсруулна

ГДТ Зорилт тодорхойлох хөтөлбөрөөс оролцогч орнуудад ямар дэмжлэг үзүүлэх вэ?

- Хэмжигдэхүйц, шалгагдахуйц, цаг хугацаагаар тодорхойлогдох ГДТ сайн дурын зорилтыг тогтооход дэмжлэг үзүүлэх
- Эдгээр зорилтод хүрэхийн тулд хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Үндэсний хэмжээнд ГДТ хариу үйлдлийн шатлалыг хэрэгжүүлэх дээд түвшний нот бичиг үйлдэхэд дэмжлэг үзүүлэх.
- Оролцогч талуудыг хамруулсан ГДТ зорилт тодорхойлох техник туслалцааны механизм болон харилцан суралцах нөхцлийг бүрдүүлж өгнө.

Суурь нөхцөл 4. ГДТ зорилтыг хангах

ГДТ-д зориулагдсан урт хугацаанд тогтвортой санхүүжилтийг бий болгох

ГДТ зорилтыг хэрэгжүүлэх урт хугацаанд тогтвортой үйлчлэх санхүүжилт

Үндэсний төсөв

Хувийн хэвшил

Олон улсын санхүүжилтийн механизм

Санхүүжилтийн шинэлэг эх үүсвэр

Олон талт болон хоёр талт донор байгууллагууд



Суурь нөхцөл 4. ГДТ зорилтыг хангах

ГДТ-д чиглэсэн хамтын ажиллагааг бий болгох

Газрын менежмент болон ГДТ бодлогод хамааралтай бүхий л талуудын хооронд сайн хамтын ажиллагааг бий болгох нь ГДТ зорилт бодит үйл хэрэг болох суурь нөхцөл юм. Энэ үйл явцад дараах асуудлуудыг анхаарах нь чухал. Үүнд:

- ГДТ зорилтыг үндэсний, аймгийн, сумын зэрэг бүх түвшний байгууллагуудын үйл ажиллагаа болон орон нутгийн хөгжлийн баримт бичигт тусгах
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бий болгох замаар хувийн хэвшил газрын тогтвортой менежментэд хөрөнгө оруулах болон эдийн засгийн үр ашигтай том хэмжээний ГДТ төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх
- Төр, хувийн хэвшил зэрэг өргөн хүрээг хамарсан санхүүжилтийн холимог эх үүсвэрийг бий болгох болон Уур амьсгалын Ногоон Сан, Даян Дэлхийн Байгаль Хамгаалах Сан, олон талт хөгжлийн банкууд, бүсийн хэмжээний хөгжлийн банкууд болон өөр бусад талуудыг татан оролцуулах
- ГТМ-ийг өргөн хүрээнд нэвтрүүлэх, байгалийг нөхөн сэргээхэд чиглэсэн үндэсний, бүсийн болон олон улсын үүсгэл санаачлагад идэвхитэй оролцож ГДТ зорилтыг хангах суурь шаардлага болох уян хатан хамтын ажиллагааг өрнүүлэх.

Ямар үр дүн хүлээж байна вэ?

- Үндэсний голлох бодлого, амлалт, баримт бичгүүдэд ГДТ зорилтыг тусгана.
- Өөрчлөлт шинэчлэл авчрах томоохон төсөл, хөтөлбөр болон санхүүжилтийн шинэлэг загварын жишиг баримт бичиг бүрдэнэ.

ГДТ Зорилт тодорхойлох хөтөлбөрөөс оролцогч орнуудад ямар дэмжлэг үзүүлэх вэ?

- ГДТ зорилтыг хангах олон улсын болон үндэсний бодлого, амлалтуудыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх
- Өөрчлөлт шинэчлэл авчрахуйц ГДТ томоохон төсөл, хөтөлбөр болон санхүүжилтийн шинэлэг хэлбэрүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.
- ГДТ болон ГДТ зорилтуудыг тодорхойлсноор бий болох үр ашгийг олон нийтэд таниулан ойлгоход дэмжлэг болно.
- ГДТ хариу үйлдлийн шатлалыг хэрэгжүүлэх, өргөн хүрээнд нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд олон талт хамтын ажиллагааг бий болгох чиглэлд дэмжлэг үзүүлнэ.

Хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас авсан сургамж:

ГДТ зорилтыг тодорхойлохыг зорьж буй улс орнуудад өгөх зөвлөгөө

1. ГДТ зорилтуудыг улс төрийн дээд түвшинд хүлээн зөвшөөрсөн байх

Юуг анхаарах вэ?

- ГДТ зорилтуудыг тодорхойлохдоо улс орон бүр өөрийн онцлогийг нухацтай авч үзэх хэрэгтэй. Үүний тулд загвар төслүүдийн хүрээнд боловсруулсан шалгуур үзүүлэлтүүдийг өөрийн орны нөхцөлд тохирох нэмэлт үзүүлэлтээр баяжуулах замаар дээрхи шаардлагыг хангаж болно.
- ГДТ зорилтуудыг тодорхойлмогц тэдгээрийг улс төрийн дээд түвшинд хүлээн зөвшөөрч харгалзах институцийн дэмжлэгийг авах нь зөв. Эдгээр зорилтуудыг салбар хоорондын хамтын үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх бөгөөд шинжлэх ухаан, иргэний нийгэм, хувийн хэвшлийн бүхий л сонирхогч талуудын оролцоог хангах хэрэгтэй

2. Мониторингийн чадавхийг сайжруулах ГДТ шалгууруудыг бүрдүүлэх

Юуг анхаарах вэ?

- Газрын бүрхэвч, газар ашиглалт, газрын бүтээмжийн өөрчлөлтийг тодорхойлох, хөрсний органик нүүрстөрөгчийн мэдээллийн сан байгуулах болон мэдээллийг бүрдүүлэх аргазүйг үндэсний ба даян дэлхийн түвшинд улам нарийвчлан сайжруулах шаардлагатай. Ингэснээр ГДТ зорилтын хэрэгжилтэнд хийх мониторинг илүү бодитой болох нөхцөл бүрдэх юм.
- Хэдийгээр ГТМ-ийг газрын бүрхэвч, газар ашиглалт, бүтээмжийн шалгуур үзүүлэлтүүдэд түшиглэн хялбар дөт аргаар мониторинг хийж болох ч хөрсний органик нүүрстөрөгчийг тодорхойлох аргыг бий болгох нь уур амьсгалын өөрчлөлтийн бодлоготой уялдуулах гол шалгуур болох юм.
- Даян дэлхийн хэмжээнд байгуулсан хөрсний нүүрстөрөгчийн мэдээллийн сан нь газрын судалгаа болон загварчлалд суурилсан байна. Хөрсний органик нүүрстөрөгчийн агууламж, тэд дундаа амьд организмд агуулагдах хэмжээнд мониторинг хийх тогтолцоог олон улсад хүлээн зөвшөөрөгдөх стандартын дагуу байгуулах хэрэгтэй. Үүнийг ойрын хэт улаан туяаны технологи ашиглан хэрэгжүүлэх хямд төсөр боломж бий.

3. ГДТ үйл ажиллагааг харилцаа холбоо, ухуулга сурталчилгаа, олон нийтийн боловсролын хөтөлбөрөөр дэмжих

Юуг анхаарах вэ?

- Олон талын сонирхолыг бий болгох, мэдлэг солилцоог өргөжүүлэхийн тулд ГДТ үйл ажиллагаа нь даян дэлхийн, үндэсний, бүс нутгийн зэрэг бүхий л түвшинд харилцаа холбоо, ухуулга сурталчилгаа, олон нийтийн боловсролын цогц үйл ажиллагаатай уялдсан байх шаардлагатай. Ингэснээр ГДТ зорилтын нийгэм болон эдийн засгийн хэрэгцээ өсөн нэмэгдэх юм.
- Бүхий л сонирхогч талуудын эрх тэгш оролцоог хангах нь Засгийн газраас тодорхойлсон ГДТ бодлогод сайн дурын оролцоог нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Улс төрийн ийм дэмжлэг нь газрын тогтвортой менежмент, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг тэлэх боломжийг олгоно. Ингэхийн тулд ГДТ чиглэлийн сургалт, чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг тодорхой бодлогоор дэмжих нь чухал.

4. ГДТ зорилтыг хэрэгжүүлэх “халуун цэгүүд”-ийг тодорхойлж, өөрчлөлт авчрах төслүүдийг боловсруулах

Юуг анхаарах вэ?

- Өмнө хуримтлагдсан сургамжийг үйл ажиллагаа болгох нь газрын тогтвортой менежмент болон нөхөн сэргээлтийн арга хэмжээг ГДТ зорилт тодорхойлох үйл явцын хүрээнд илрүүлсэн “халуун цэг”-үүдэд чиглэсэн өөрчлөлт авчрах төслүүдийг боловсруулах явдал юм.
- ГДТ зорилтыг хэрэгжүүлэхэд богино хугацааны, үр ашиг багатай үйл ажиллагаанд түшиглэх учиргүй юм. Ингэхийн тулд ландшафтад суурилсан арга барилыг нэвтрүүлэх нь чухал.
- Өөрчлөлт авчрах, үр ашиг өндөртэй төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх эсэх нь бүхий л талуудын


ялангуяа шинэлэг, ул суурьтай санхүүгийн дэмжлэг үзүүлэх чадавхитай хувийн хэвшлийн оролцоо хэрхэн хангагдахаас хамаарна.

5. ГДТ зорилтын хэрэгжилтийн мониторинг, үнэлгээний систем

Юуг анхаарах вэ?

- ГДТ зорилтын хэрэгжилтэнд мониторинг хийх, үнэлгээ өгөх ажилд газрын менежмент, газрын доройтлын мониторинг, үнэлгээний мэдээллийн системийг байгуулах нь чухал. Ийм Мониторинг, Үнэлгээний Систем нь тогтвортой үйл ажиллагаа явуулж буй бүтцэд төвлөрч салбар хоорондын уялдааг хангахуйцаар зохион байгуулагдсан байх нь тохиромжтой.
- Ийм тогтолцоог одоо байгаа тогтолцоо болон REDD+ зэрэг санаачлагаар бий болсон чадавхид түшиглэхийг аль болох хичээх нь зүйтэй. Эдгээр тогтолцооны хүрээнд бий болсон мэдээлэл нь бүх яамдад хүртээмжтэй, газар ашиглалтанд нөлөө үзүүлэхүйц байх ёстой. Яам тус бүр өөрийн салбарын мэдээллээр системийн агуулгыг баяжуулах боломжтой байхаас гадна төвлөрсөн мэдээлэл хадгалах тогтолцоонд орох эрхтэй байна. Мэдээллийн системийн бүх мэдээлэл нь орон нутгийн түвшинд мөн нээлттэй байж ард иргэд, иргэний нийгмийн бүлгүүдэд мэдээллээ түгээж байхыг шаардана.
- Хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагууд нь мэдээллийг тухай бүр авч хэрэглэх эрхээр хангагдаж байж гэмээнэ газар, газрын доройтлыг нөхөн сэргээх санал, санаачлагад хариу үйлдэл үзүүлэх, хөрөнгө оруулах боломжийг нээж өгнө.
- Мониторинг, Үнэлгээний Систем нь газартай холбоотой гол шалгуур үзүүлэлт, тэр дундаа газрын бүрхэвч, газар ашиглалт, газрын бүтээмж, хөрсний органик нүүрстөрөгчийн агууламж, тэдгээрт гарч буй өөрчлөлтийн талаархи мэдээллийг тогтмол шинэчлэн гаргаж байх шаардлагатай.

*Загвар төсөлд ямар улс орнууд
хамрагдсан бэ?*



Ашигласан хэвлэл

1. http://www.un.org/en/events/desertification_decade/whynow.shtml
2. <http://www.un.org/en/events/desertificationday/background.shtml>
3. Economics of Land Degradation Initiative: Report for policy and decision makers” (2015). http://eld-initiative.org/fileadmin/pdf/ELD-pm-report_05_web_300dpi.pdf
4. UNCCD (2016). Scientific Conceptual Framework for Land Degradation Neutrality. A Report of the Science-Policy Interface. Barron J. Orr, Annette L. Cowie, et al. (Forthcoming)
5. <http://www.bonnchallenge.org/content/challenge>
6. <http://forestdeclaration.org>
7. <http://4p1000.org/understand>
8. <http://www.wri.org/our-work/project/initiative-20x20>
9. <http://www.wri.org/our-work/project/AFR100/about-afr100>
10. <http://terrafrica.org>
11. The Resilience, Adaptation Pathways and Transformation Assessment (RAPTA) Framework (2015),
12. <http://www.stapgef.org/stap/wp-content/uploads/2015/03/CSIRO-STAP-Resilience-Adaptation-Transformation-Assessment-Framework-Report.pdf>
13. WOCAT (2012): DESIRE for Greener Land: Options for Sustainable Land Management in Drylands https://www.wocat.net/fileadmin/user_upload/documents/Books/DESIRE_BOOK_low_resolution.pdf

Энэхүү товхимолд ашигласан бүх төрлийн график дизайныг НҮБ-ын ЦТК-ийн Даян Дэлхийн Механизмаас боловсруулсан хэлбэрээр оруулсан болно.

